



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар A/12

Даланзадгад

Эрүүл мэндийн эрдэм шинжилгээ судалгаа,
технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах
тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 415 дугаар тушаалын 4.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны A/195 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх эрдэм шинжилгээ судалгаа, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зөвлөлийн ажиллах дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дүрмийн дагуу үйл ажиллагааг явуулах, эмч мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх, тэдний нэвтрүүлсэн шинэ технологи, тэргүүн туршлагыг баталгаажуулах, сурталчлах, нэвтрүүлэх ажлыг чанартай зохион байгуулахыг зөвлөл, түүний гишүүдэд үүрэг болгосугай.

3. Цаашид зөвлөлийн гишүүдэд өөрчлөлт орох болон зөвлөлийн даргын санал болгосноор тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх, зөвлөлийн ажлын төлөвлөгөө түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийн хэлтэс /Б.Мидэрсүрэн/-т даалгасугай.

ДАРГА  Д.ӨНӨРЖАРГАЛ

3047751
КЭСА.024

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 03 сарын 14-ны өдрийн
А/12 тоот тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА, ТЕХНОЛОГИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Эрүүл мэндийн газрын дарга

Орлогч дарга: Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд:

Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга

Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга

Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Сувилахуйн мэргэжилтэн

Эмийн мэргэжилтэн

БОЭТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч

БОЭТ-ийн Мэдрэлийн тасгийн эрхлэгч

БОЭТ-ийн Мэс заслын тасгийн эрхлэгч

Дотрын тасгийн эрхлэгч

Говийн мэлмий нүдний эмнэлгийн дарга


Хэрмэн цахиурын эмнэлгийн их эмч

Өрхийн сувилагч мэргэжилтний төлөөлөл /Ж.Цагаанхүү Шим билэг/

Халдвартын мэргэжилтний төлөөлөл /М.Буманцэцэг Нинж ачлал/

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлт, хөтөлбөр стратеги хариуцсан мэргэжилтэн С.Даваасүрэн

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 03 сарын 17-ны өдрийн
А/12 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА, ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эрүүл мэндийн эрдэм шинжилгээ судалгаа, технологийн зөвлөл нь тус аймагт ажиллаж байгаа их дээд, тусгай дунд боловсролтой мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх, судалгааны ажлыг захиалах, дэмжлэг үзүүлэх болон шинэ технологи, шинэ санаа, тэргүүн туршлагыг баталгаажуулах, мэдээллийн сан үүсгэх үндсэн үүрэгтэйгээр ажиллана.

1.2 Зөвлөл нь аймгийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн эрдэм шинжилгээний бодлого боловсруулах, асуудлыг шийдвэрлэхэд хөрөнгө хүчийг төвлөрүүлэх, судалгааны ажлын үр дүн, технологийн эдийн засгийн үр дүнг үнэлэх, практикт нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах зорилготой.

Хоёр. Зөвлөлийн удирдлага зохион байгуулалт

2.1. Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг орлогч дарга болон нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

2.2 Нарийн бичгийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг зохион байгуулах, зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан бичих, архивын бүрдэл үүсгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

2.3 Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэр нь протокол зөвлөмж хэлбэрээр гарах бөгөөд Эрүүл мэндийн газрын даргын тушаал, бусад шийдвэрийн хэлбэрээр хэрэгжинэ. Зөвлөл нь ЭМГ-ын албан хэвлэмэл хуудас, тамга тэмдэг, албан бичгийн нүүрийг хэрэглэнэ.

2.4 Зөвлөлийн хурлыг улиралд 1-с доошгүй удаа хийхээр төлөвлөх бөгөөд шаардлагатай гэж үзвэл ээлжит бус хурлыг хуралдуулж болно.

2.5 Хурлыг дийлэнх олонхын ирцтэйгээр хийх бөгөөд хурлаас гарсан шийдвэрийг дийлэнх олонхын саналаар баталж, протоколд хөтлөн дарга нарийн бичиг гарын үсгээр баталгаажуулна.

Гурав. Зөвлөлийн үүрэг

- 1.1 Эрүүл мэндийн салбарын эрдэм шинжилгээ, технологийн тулгамдсан асуудлыг тодорхойлох, чиглүүлэх;
- 1.2 Эрдэм шинжилгээний ажлын санал санаачилгыг дэмжих, захиалга хүлээн авах, боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайланг сонсох, хэлэлцүүлэх, үр дүнг практикт нэвтрүүлэх ажлыг хэлэлцэн шийдвэрлэж, зохион байгуулах;
- 1.3 Технологийн өнөөгийн түвшнийг үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, эрдэм шинжилгээний болон технологийн чиглэлээр ойрын болон хэтийн төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- 1.4 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинэ технологи, сайн туршлагыг нэвтрүүлэх, баталгаажуулах, зөвшөөрөл олгох;
- 1.5 Практик өгөөж, үр ашиг багатай технологи, удаашралтай хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, судалгааны ажилд үнэлгээ дүгнэлт гаргах, зогсоох хүртэл саналыг холбогдох байгууллагад санал болгох;
- 1.6 Гадаад дотоод, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинэ технологиудыг нутагшуулах;
- 1.7 Шинэ технологийн ололт, судалгаа шинжилгээний бүтээлүүдийг хүлээн авах, хэлэлцэн дүгнэлт гаргах;
- 1.8 Шинэ бүтээл оновчтой саналын эдийн засгын үр ашгийг хэлэлцэх, практикт нэвтрүүлэх талаар зөвлөгөө зөвлөмж, зөвшөөрөл олгох, мэдээллийн сан үүсгэх;
- 1.9 Эмч мэргэжилтнүүдийн их, бага хурал, эрдэм шинжилгээ-практикийн бага хурал, симпозиум, семинар, үзүүлэх сургууль ШБОС-ын ба бүтээлийн тайлан үзэсгэлэн, туршлага нэвтрүүлэх, ном, товхимол лекц, мэдээллийн материал гаргах, нэрэмжит үзлэг явуулах, гадаад дотоодын сэтгүүлд хэвлүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэрэглэн судалгаа шинжилгээ, технологийг танилцуулах сурталчлах, хэлэлцүүлэх, нийтийн хүртээл болгох;

- 1.10 Эмч мэргэжилтнүүдийн мэргэжлийн зэрэг цол олгох, ахиулах, магистрант, докторант бэлтгэх асуудлыг бодлогоор дэмжин бусад байгууллага, мэргэжлийн нийгэмлэгүүдтэй хамтран ажиллах;
- 1.11 Эмч мэргэжилтнүүдийг судалгааны ёс зүй, судалгааны арга зүйгээр чадавхжуулах, эрдэм шинжилгээний ажил хийхэд тусалж, дэмжлэг үзүүлнэ;
- 1.12 Сайн дурын үндсэн дээр эвлэлдэн холбоо нийгэмлэг байгуулан ажиллах эмч мэргэжилтнүүдийг чиглүүлэх, дэмжих бодлого барих;
- 1.13 Орон нутгийн ЭМ-ийн тулгамдсан асуудлуудыг өөрсдөө судалж гарах арга зам шийдлийг танилцуулах, үр дүнг нь тооцох;

Дөрөв. Зөвлөлийн эрх

- 4.1 Зөвлөлөөс эрхлэн тулгамдсан асуудлын хүрээнд эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн гэх мэт арга хэмжээнүүдийг зохион байгуулах;
- 4.2 Эрдэм шинжилгээ судалгаа, технологийн чиглэлээ орон нутгийн журам дүрэм боловсруулах;
- 4.3 Шилдэг бүтээл, шилдэг судлаач шалгаруулан урамшуулах, онцгой бүтээл гаргасан эмч мэргэжилтнүүдийг алдаршуулах, шагнал урамшуулалд тодорхойлох;
- 4.4 Зөвлөлийн гишүүдийн ажлыг үнэлж урамшуулах журам боловсруулан шийдвэрлүүлэх;
- 4.5 Зөвлөлийн хэвлэлийг эрхлэн гаргаж болно. Бусад зөвлөлүүд болон байгууллагуудтай хамтран ажиллах. Багийн гишүүдээ чадваржуулах арга хэмжээ авах;

Тав. Зөвлөлийн санхүүжилт

- 5.1 Зөвлөлийн үйл ажиллагаа бичиг хэрэгт шаардлагатай зардлыг ЭМГ-н санхүүжилтээр шийдвэрлэх;
- 5.2 Зарим шаардлагатай үйл ажиллагааны зардлыг тухайн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн зардлаас шийдвэрлэх;
- 5.3 Зарим шаардлагатай санхүүжилтийг төсөл хөтөлбөр хэлбэрээр орон нутгийн болон бусад эх үүсвэрээр шийдэх;